



ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН ҮР НӨЛӨӨЛЛИЙН



4 2 0 2



ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН
ҮР НӨЛӨӨЛЛИЙН

2024

Хөгжлийн Шийдэл нь мянга мянган энтрепренерүүдэд оюуны болон санхүүгийн хөрөнгө оруулалт хийж, тэдний өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, амжилтын түүхийг нь хамт бичилцэх замаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж ирсэн.

ТОВЧИЛСОН ҮГ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага
БЖДБ	Бичил, Жижиг, Дунд Бизнес
БЖДҮ	Бичил, Жижиг, Дунд Үйлдвэр
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОНЗ	Байгаль Орчин, Нийгэм, Засаглал
БС	Бизнесийн Сургууль
ЕХ	Европын Холбоо
ЖДБ	Жижиг, Дунд Бизнес
ЖДҮ	Жижиг, Дунд Үйлдвэр
ЖДҮГ	Жижиг, Дунд Үйлдвэрийн Газар
ЖДҮХС	Жижиг, Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сан
ЗБДС	Зээлийн Батлан Даалтын Сан
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МАА	Мал Аж Ахуй
МАДТ	Малчдын Амьжиргааг Дэмжих Төсөл
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НЖДҮҮДТ	Нийслэлийн Жижиг, Дунд, Үйлдвэр, Үйлчилгээг Дэмжих Төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОНХХ	Орон Нутгийн Хөгжлийн Хөтөлбөр
ОУБ	Олон Улсын Байгууллага
ОУТББ	Олон Улсын Төрийн Бус Байгууллага
ОУХА	Олон Улсын Хөгжлийн Агентлаг
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТОС	Тогтвортой Санхүүжилтийн Холбоо
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилго
ТЭЗҮ	Техник, Эдийн Засгийн Үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Хөдөө Аж Ахуй
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХДС	Хөгжлийг дэмжих сан
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ХХҮГ	Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газар
ХХҮХ	Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэс
ХЭДС	Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сан

ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН
МЭНДЧИЛГЭЭ




УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН
ТАНИЛЦУУЛГА



БАЙГУУЛЛАГЫН
ТАНИЛЦУУЛГА



ҮЙЛ
АЖИЛЛАГАА



ҮР
НӨЛӨӨНИЙ
ХАМРАХ
ХҮРЭЭ




САНХҮҮГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ



ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД



ХАМТЫН
АЖИЛЛАГАА



АГЛУУЛГА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



2024 онд Хөгжлийн Шийдэл ТББ-ын ажилсаг хамт олон, бүтээлч хамтрагч байгууллагууд, идэвх санаачилгатай харилцагчдынхаа хамтаар ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, экосистемийг хөгжүүлэх, ногоон болон тойрог эдийн засгийг бизнесүүдэд нэвтрүүлэх, хүнс, хөдөө аж ахуй, арьс шир, барилгын материал үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарын бизнесүүд, залуучууд, эмэгтэй энтрепренерүүд гэх мэт олон салбарт чиглэсэн донор байгууллагуудын өмнө хүлээсэн төслүүдээ амжилттай дуусгаж, орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулсан жил байлаа.

Тухайлбал, АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлсэн **“BEST ХӨТӨЛБӨР”** ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ил тод, сайн засаглалыг сайжруулан Монгол Улсын эдийн засгийг солонгоруулан хөгжүүлэх зорилготойгоор **2019-2024 онуудад таван жилийн хугацаанд Улаанбаатар хот болон 12 аймагт амжилттай хэрэгжүүлсний үр дүнд ЖДБ-үүд маань борлуулалтын орлогоо 45.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 4500 гаруй шинэ ажлын байр бий болгож чаджээ.** BEST хөтөлбөрийн онцлох өв нь ЖДБ эрхлэгчдийг санхүүгийн бус үйлчилгээгээр дэмжих нь санхүүгийн дэмжлэгээс дутахгүй эдийн засгийн өгөөжтэй болохыг төрийн байгууллагууд, санхүүгийн байгууллагууд болон ЖДБ эрхлэгчдэд өөрсдөд нь нотолж харуулсан явдал юм. Хөтөлбөрийн үр дүнд Улаанбаатар хот болон 12 аймагт ЖДБ-ийн захирлуудын клуб, ЖДБ-ийг дэмжих төрийн бус байгууллагуудыг үүсгэн хөгжүүлж үлдээснээр ЖДБ-ийн хөгжлийн экосистемд BEST хөтөлбөрийн нөлөө урт хугацаанд үргэлжлэх эхлэлийг тавьсан.

Хөгжлийн Шийдэл нь 2024 онд Оюу Толгой ХХК-ийн Орон Нутгийн Харилцааны хамт олон, Ханбогд сумын малчид, Гурван Талт зөвлөлийн гишүүд, Ханбогд Сумын Засаг даргын тамгын газрын хамт олонтой хамтран **“ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”**-ийг таван жил хэрэгжүүлэн дуусгалаа. Уг төслөөс малчдын бизнес санаачилгыг дэмжин дундын хоршоо хэлбэрээр нэгдэж чадвал сумаараа нийлээд МАА, ХАА-н салбараас олж буй орлогоо 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтойг харуулсан жишиг төслийн түүхийг эхлүүлсэндээ бахархалтай байна.

Бид 2022 оноос эхлүүлсэн Европын Холбооны санхүүжилттэй **“ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ” (SOGЕ)** төслийн хүрээнд ЖДБ-үүдийг тойрог эдийн засагт шилжих, байгаль орчинд ээлтэй, ногоон бизнесийн чиглэлээр мэдлэг мэдээлэлтэй болгох зорилготой хурдасгуур хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, **Улаанбаатар хот, Орхон, Сэлэнгэ аймгуудад нийт 878 оролцогчийг хамруулж, амжилттай үргэлжилж байна.**

“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР” -ийн хүрээнд Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газруудтай хамтран 743 иргэн, аж ахуйн нэгжийг бизнес эрхлэлтийн болон гарааны бизнесийн сургалт, зөвлөгөөнд хамруулж, ХЭДСангаас 262 бизнесийг 2.6 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт авахад нь дэмжлэг үзүүлж ажилласан.

Хөгжлийн Шийдэл ТББ ирэх жилүүдэд Монгол Улсын ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ногоон хөгжлийг дэмжих, ХАА-н хоршоодын хөгжлийн төлөө бүх оролцогч талуудтай төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн хамтран ажиллахад бэлэн байна.

Пүрэвдорж
АМАРМЭНД



УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Удирдах Зөвлөл нь орон нутгийн хөгжил, бизнес, эдийн засгийг хөгжүүлэх зорилго чиглэлийг нийгмийн хариуцлагынхаа хүрээнд дэмждэг хууль эрх зүй, боловсрол, банк санхүү болон уул уурхайн салбарын төлөөллүүд бүхий хараат бус 5 гишүүдээс бүрддэг.

Удирдах Зөвлөл нь жилд дөрвөн удаагийн ээлжит хурлыг зохион байгуулж, стратегийн болон цаг үеийн зохих шийдвэрүүдийг гаргах үүрэг бүхий удирдах дээд байгууллага юм.



Удирдах зөвлөлийн дарга

Лувсандорж

ОЮУН

МУИС-ийн БС-ийн Санхүүгийн Хөтөлбөрийн багш доктор, Профессор



Удирдах зөвлөлийн гишүүн

Зориг

ТУЯА

Нью-Урбанизм ХХК-ийн Захирал



Удирдах зөвлөлийн гишүүн

Жамбалдорж

ЭРДЭНЭЧИМЭГ

Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхийлөгч асан



Удирдах зөвлөлийн гишүүн

Рагчаа

ИЧИННОРОВ

Хаан банкны Орон Нутгийн Иргэдийн Банкны Захирал



Удирдах зөвлөлийн гишүүн

Тогтох

ЭНХЖАРГАЛ

Хасбанкны Иргэдийн Банкны Хэлтсийн Захирал

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ШИЙДЭЛ ТАТ

2008-2024

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ нь 2008 оны 8-р сарын 14-ний өдөр үүсгэн байгуулагдсан хувийн хэвшлийг хөгжүүлэх, тэдэнд энтрепренер сэтгэлгээ, хандлага, ур чадварыг олгох, засаглалыг сайжруулах, борлуулалтын зах зээл, санхүүжилттэй холбох зэрэг олон талын цогц үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байгаа мэргэшсэн туршлага бүхий хамт олноос бүрдсэн Монгол Улсад төвтэй, ашгийн бус байгууллага юм.

Бид байгуулагдсан цагаас хойш бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид, малчид, хоршоод, төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд зэргийг багтаасан **39.5 мянга орчим үр шим хүртэгч** бүрийнхээ үр дүнд суурилсан өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, Засгийн газар түүний харъяа төр захиргааны байгууллага, олон улсын хандивлагчид, санхүүгийн байгууллагуудтай хамтран ойролцоогоор **65 сая орчим ам.долларын санхүүжилт бүхий 100 орчим хөгжлийн төсөл, хөтөлбөрийг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн бүс нутгуудад хэрэгжүүлж, Монгол Улсын эдийн засгийг солонгоруулан хөгжүүлэх, ядуурал, ажилгүйдлийг бууруулахад өөрийн үүрэг, хувь нэмрээ оруулан ажиллаж байна.**

АЛСЫН ХАРАА

Хөгжлийн Шийдэл нь бизнесийн хөгжлийг дэмжих мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлэгч **ШИНЭЛЭГ, ҮР ДҮНТЭЙ, ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА** байна.



БИЗНЕСИЙН ӨСӨЛТ

- Өргөжин сайжирсан бизнесийн тоо
- Борлуулалтын орлогын өсөлт
- Нэмэгдүүлсэн ажлын байр
- Зээл, санхүүжилтэд хамрагдсан тоо

БИЗНЕСИЙН ЭКОСИСТЕМ

- Бодлогын бичиг баримтууд, өмгөөлөл, нөлөөллийн санал, санаачилгын тоо
- Чадавхжсан төрийн албан хаагчид
- Чадавхжуулсан иргэний нийгмийн байгууллагуудын тоо

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

- Үйлчилгээнд хамрагдсан **эмэгтэй** бизнес эрхлэгчдийн тоо
- Үйлчилгээнд хамрагдсан **залуучуудын** тоо
- Хүлэмжийн хий бууруулалт
- Ногоон санхүүжилтэд хамрагдсан бизнесийн тоо
- Ногоон санхүүжилтэд хамруулсан зээлийн дүн
- Ногоон тэтгэлэгт хамрагдсан бизнесийн тоо
- Үйлчилгээнд хамрагдсан нийгмийн бизнесүүд
- Шинэ бизнесийн тоо
- Албан бизнес болсон тоо



ХҮНИЙ НӨӨЦ

Манай байгууллага нь одоогоор бизнес эрхлэлтийг хөгжүүлэх чиглэлээр мэргэшсэн үйл ажиллагаа, санхүү, админ, мониторингийн багуудаас бүрдсэн бүтэн цагийн 25 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай бизнесийн зөвлөхүүд нь Олон Улсын (СМС), Үндэсний Зөвлөхийн (МСМС) гэрчилгээжсэн зөвлөхүүд бөгөөд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO), Залуу Бизнесийн Олон Улсын Сүлжээ (YBI), Даян Дэлхийн Нийгмийн Энтрепренерүүдийн Сүлжээ (GSEN) зэрэг байгууллагуудын гэрчилгээт сургагч багш нараас бүрдсэн баг хамт олон юм.

Мөн бид хөдөө орон нутгийн 21 аймагт өөрсдийн гэрээт бизнесийн зөвлөхүүдтэй ажиллаж байна.

21 АЙМАГТ БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХҮҮД

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Залуучууд, эмэгтэйчүүд, тусгай хэрэгцээт иргэдийн бизнес эрхлэлтийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Хүүхэд залуусын санхүүгийн болон энтрепренер чадавхыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанууд зохион байгуулах
- Ногоон эдийн засаг, эко шошго, ногоон санхүүжилтийн бодлого, шийдвэрүүдийн санаачилгыг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг санаачлах, хэрэгжүүлэх
- Байгаль орчны болон нийгмийн чиглэлээр хэрэгжиж буй төслүүдийн үнэлгээ, мониторинг хийх, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, тогтвортой орлогод суурилсан загвар, чадавхыг хөгжүүлэх
- Нийгмийн энтрепренершипийг хөгжүүлэх загварын сургалт, зөвлөх үйлчилгээ
- Зохистой хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэх, албан болон албан бус бизнесийн эрх бүхий сургалтуудыг зохион байгуулах

БИЗНЕСИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ЭНТРЕПРЕНЕРШИП ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Гарааны болон жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх
- Бизнес санааг хөгжүүлэх, бүтээгдэхүүн хөгжил, загварчлан сэтгэхүй (Design Thinking)
- Компанийн ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТИЙГ хөгжүүлэх
- БИЗНЕС ТӨСӨЛ, ТӨЛӨВЛӨГӨӨ БИЧИХ, ТАНИЛЦУУЛАХ, хамгаалах
- БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, АЖИЛТНУУДЫН ЗӨӨЛӨН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ
- ЗАХ ЗЭЭЛ, БОРЛУУЛАЛТАД ХОЛБОХ, сошиал медиа, маркетингийн чадавхыг сайжруулах, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, тендер, худалдан авалтын материал бүрдүүлэх
- Зээл санхүүжилтэд холбох, зээлийн бичиг баримт бүрдүүлэлт
- Дотоодын болон олон улсын уралдаан тэмцээн, арга хэмжээнүүдэд бэлтгэн оролцуулах
- ХОРШООНЫ ЗАСАГЛАЛ, БИЗНЕС ЗАГВАР, МЕНЕЖМЕНТ ХӨГЖҮҮЛЭХ
- Тойрог эдийн засгийн бизнес загварын сургалт, зөвлөх үйлчилгээ
- Бичил санхүүжилтийн тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, сонгон шалгаруулах
- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ТЭЗҮ, хөрөнгө оруулалтын төслүүдийг боловсруулах

**БИЗНЕСИЙН
ЭКОСИСТЕМ
ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА:**

- УЛС, БҮС, ОРОН НУТГИЙН ТҮВШНИЙ БИЗНЕСИЙН ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААГ ХИЙХ
- БИЗНЕСИЙН ОРЧНЫ ХУУЛЬ ЭРХЗҮЙ, БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ, ЖУРАМ, УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ЖДБ-ИЙГ ДЭМЖИХ хөтөлбөрүүдийг боловсруулах
- Бүсчилсэн хөгжил, үйлдвэрлэлийн парк, хот төлөвлөлт зэрэг бодлогын бичиг баримтуудад хувийн хэвшлийн салбарыг дэмжих, ХАБ төвүүд, кластер, инкубаторууд зэрэг зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөлтийг гүйцэтгэх, эдийн засгийн үр өгөөж болон хэрэгжих боломжийг үнэлж гаргах
- Хувийн хэвшлийг дэмжих төрийн байгууллагуудын засаглал, авлигаас ангид, ил тод байдлыг сайжруулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдыг чадавхжуулах
- Бизнесүүдийг төлөөлж буй нэгдэл клубууд, холбоод, иргэний нийгмийн байгууллага, ТББ-ыг стратеги, менежемент, нөлөөлөл үзүүлэх, санхүүжилт татах, төслийн санал боловсруулах чиглэлээр чадавхжуулах
- Бизнесийн орчин, бизнесийг хөгжүүлэх мэдлэг ур чадварыг банк, санхүүгийн байгууллагын ажилчдад олгох
- ЖДБ-ийн Өрсөлдөх чадварын судалгаа
- Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, тухайлбал аялал жуулчлал, хүнсний үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх загварыг боловсруулах, засаглалыг сайжруулах хөгжлийн бодлого, стратегийг гаргах

АРГАЧЛАЛ

● **БИЗНЕСИЙН СУРГАЛТ**

● **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ-ОЛОН УЛСЫН БОЛОН ҮНДЭСНИЙ ГЭРЧИЛГЭЭТ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ**

● **МЕНТОРИНГ**

● **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТ, ФОРУМ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

● **ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА**

● **ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ-STUDY TOUR**

● **КӨҮЧИНГ**

● **ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ "СТАРТ-АП" ХӨТӨЛБӨР**

● **БИЗНЕСИЙГ ТҮРГЭВЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТИЙН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ "ХУРДАСГУУР-ACCELERATION" ХӨТӨЛБӨР**

● **СУДАЛГАА, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ, ҮНЭЛГЭЭ**

БИДНИЙ ҮР НӨЛӨӨ

Хөгжлийн Шийдэл ТББ нь Монгол Улс дахь бичил, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, төрийн бус байгууллага, төрийн байгууллагуудад голлон чиглэж ажилладаг. Манай үр шим хүртэгчид Улаанбаатар хот болон 21 аймаг дахь хувийн хэвшлийн олон салбарын оролцогч талууд байдаг бөгөөд 2008 оноос хойш 2024 оны 12-р сарын байдлаар нийт хугацаанд бид 39,586 үр шим хүртэгчид дэмжсэний 60% нь эмэгтэйчүүд, 47% нь 18-35 насны залуучууд, 3% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

2024 онд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй Алсын Хараа-2050, Шинэ Сэргэлтийн Бодлого, Хүнсний Хөтөлбөр, Бүсчилсэн Хөгжлийн Бодлого, Шинэ Хоршоо Хөдөлгөөн зэрэг хөтөлбөрүүдтэй уялдсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Хөгжлийн Шийдэл ТББ нь борлуулалтын өсөлт, ажлын байр бий болгох зэрэг томоохон үр дүнд хүрч, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID), Азийн Хөгжлийн банк (ADB), Европын Холбоо (EU), Свич-Эйшиа (Switch Asia), НҮБ (UN), Оюу Толгой ХХК зэрэг санхүүжүүлэгч олон улсын донор байгууллагуудын зарчмын дагуу тэдний өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлсэн жил байсан. Бидний үр дүнтэй хөтөлбөрүүд нь төрийн болон хувийн секторын байгууллагуудтай сайн түншлэлийг бий болгож, жижиг, дунд бизнесийн бодлогыг шинэчлэх, удирдлагыг сайжруулах, нээлттэй нийгмийг дэмжих чиглэлээр амжилттай ажилласан.

ХӨГЖЛИЙН
ШИЙДЭЛ

25%

Албан бизнес
эрхлэгч

60%

Эмэгтэй бизнес
эрхлэгч

75%

Албан бус бизнес
эрхлэгч

47%

18-35 насны бизнес
эрхлэгч

3%

Хөгжлийн
бэрхшээлтэй
иргэд

39,586

ҮР ШИМ ХҮРТЭГЧ
НИЙТ БИЗНЕС
(2024)

16,266

Өргөжин сайжирсан бизнес

1,525

355

Санхүүгийн тэтгэлэгт хамрагдсан бизнес

43

5,804

Шинэ бизнес

64

13,396

Амжилттай зуучилсан зээлдэгч бизнес эрхлэгч

1,316

1,937

Ментор

111.9
тэрбум төгрөг

454.0
тэрбум төгрөг
Амжилттай зээлийн зуучлал

1,382

Бизнесийн бүлэг хоршоо, төрийн бус байгууллага

177

865

Төрийн бус байгууллага, бизнес холбоод

48

32,419

16-35 насны бизнес эрхлэгч

5,902

69,904

Сургалтад хамрагдсан хүмүүс

7,473

26,345

Шинээр бий болсон ажлын байр

1,166

6.4

тэрбум төгрөг

Санхүүгийн буцалтгүй тэтгэлэг

1.7
тэрбум төгрөг

57.3

тэрбум төгрөг
Борлуулалтын орлогын өсөлт

13.2
тэрбум төгрөг

2008-2024 он

2024 он

355

Санхүүжилт авсан
горилогчийн тоо

Санхүүжилтийн
дүн (төгрөг)

6.4

тэрбум
НИЙТ
САНХҮҮЖИЛТ

20

200 сая

ТОГТВОРТОЙ БИЧИЛ
УУРХАЙ ТӨСӨЛ

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ

32

1.4
тэрбум

ХАА-Н МАРКЕТИНГ
ТӨСӨЛ

ДЭЛХИЙН БАНК

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН БИЧИЛ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРҮҮД

/2008-2024/

Хөгжлийн Шийдэл ТББ нь бичил санхүүгийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэн банк санхүүгийн байгууллагын шаардлага хангаж чадахгүй, гарааны болон шинэ санаа, инноваци, технологи нэвтрүүлж байгаа бизнесүүдэд бичил санхүүгийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Бид 2024 онд 282 горилогчдоос 235 горилогчдыг хурдасгуур хөтөлбөрт хамруулан 43 горилогчдод 423.9 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Хөгжлийн Шийдэл ТББ нь нийт хугацаанд **355** горилогчдод **6.4 тэрбум** төгрөгийн бичил санхүүжилт авахад тусалжээ.

462.3 сая

ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ БА
НОГООН БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛД
АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН САЛБАРТ
БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР
ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨСӨЛ

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

15

1.7
тэрбум

BEST
ХӨТӨЛБӨР

АНУ-ЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ

176

280 сая

ГАРААНЫ БИЗНЕСИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ
ТӨСӨЛ

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТЭГЭР

28

1.5
тэрбум

МАЛ АЖ АХУЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

ОЮУ ТОЛГОЙ ХХК

7

400 сая

ДАВАН ТУУЛАХ, ДАСАН
ЗОХИЦОХ ЧАДВАРТАЙ
МАЛЧИД ТӨСӨЛ

МЕРСИ КОР

10

200 сая

ЗАЛУУ МАЛЧДЫН
ХӨТӨЛБӨР

НУБ-ЫН ХҮН АМЫН САН

20

44

45 сая

SOGE төсөл

ЕХ, СВИЧ-ЭЙШИА

3

221.7 сая

БИЗНЕС ЭРХЛЭГЧ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ТӨВ ТӨСӨЛ

КОЙКА

ОРЛОГО

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН
САНХҮҮЖИЛТ

89%

ДОТООДЫН БАЙГУУЛЛАГЫН
САНХҮҮЖИЛТ


10%

БУСАД ОРЛОГО

1%

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЗАРДАЛ



ХЭРЭГ ЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

1
BEST
ХӨТӨЛБӨР
2019-2024

2
ЗАЛУУЧУУДЫН
БИЗНЕС
САНААЧИЛГА
(YOUTH BUSINESS
MONGOLIA) ХӨТӨЛБӨР
2013-2024




3 ОРОН НУТГИЙН
ХӨДӨӨ АЖ
АХУЙГ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР
2019-2024

4 “ЭДИЙН ЗАСГИЙН
НОГООН ШИЛЖИЛТ”
СОGE ТӨСӨЛ
2022-2025

5 МОНГОЛ УЛСЫН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЛБАРТ ТОЙРОГ
ЭДИЙН ЗАСАГ БА
НОГООН БИЗНЕСИЙН
ЧИГЛЭЛД БЖДБ
ЭРХЛЭГЧДИЙГ
ЧАДАВХЖУУЛАХ
ТӨСӨЛ
2023-2025

6 ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР







1

BEST ХӨТӨЛБӨР 2019-2024

АНУ-ын ОУХА-ийн санхүүжилттэй Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлсэн **BEST ХӨТӨЛБӨР** нь ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ил тод, сайн засаглалыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг солонгоруулан хөгжүүлэх зорилготойгоор 2019 оноос таван жилийн хугацаатай Улаанбаатар хот болон 12 аймагт үр дүнтэй хэрэгжиж, 2024 онд амжилттай хаагдав.

BEST

ХӨТӨЛБӨР

2019-2024

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөх.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД:

- ЖДБ-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх;
- ЖДБ-ийн засаглалыг сайжруулах;
- ЖДБ-ийн үйл ажиллагааг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагуудын ил тод байдлыг хангах, хяналтын тогтолцоог бэхжүүлэх;
- Бизнесийн хөгжлийн стратегийг тодорхойлоход чиглэсэн судалгааг хийх;
- Цаашид тогтвортой хөгжих боломжтой, санхүүжилт авах чадамжгүй төрийн бус байгууллага, гарааны болон жижиг бизнес эрхлэгчдэд бичил санхүүжилт олгох.

ЧАДАВХЖСАН ЖДБ

34,900 ЖДБ

68%

Эмэгтэй

32%

Эрэгтэй

Орон нутгийн нийт ЖДБ → **69%**

БОРЛУУЛАЛТЫН
ӨСӨЛТ

4,440

ЖДБ-ийн
борлуулалт

45.5

тэрбум төгрөгөөр
өссөн.

ШИНЭ АЖЛЫН
БАЙР

4,557

шинэ ажлын
байр үүссэн.

Монгол Улсын нийт ЖДБ-ийн 2020-2024 онд бий болгосон шинэ ажлын байрны - 9.2%

Хөтөлбөр нь нийт хугацаанд **35 мянга орчим ЖДБ**-т хүрч ажилласан бөгөөд **5,397 бизнест** үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд шаардлагатай нийт **329 тэрбум төгрөг** (90 сая ам.доллар)-ийн санхүүжилт авахад дэмжлэг үзүүлснээс гадна олон мянган бизнес эрхлэгчдийг санхүүгийн удирдлага, маркетинг, бизнесийн зээлийн бичиг баримт боловсруулах зэрэг чухал ур чадваруудад сургалаа. Мөн бизнесүүд борлуулалтын орлогоо **45.5 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлж, **4,500 гаруй шинэ ажлын байр** бий болгоход тусалсан нь Монгол Улсын бизнесийн орчныг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН 2019-2024

ЖДБ-ИЙН ЭКОСИСТЕМ

5,397 ЖДБ
329.7 тэрбум төгрөгийн зээл

1,438 ЖДБ
Засаглал сайжирсан.

176 Грант хүртэгчид
1.7 тэрбум төгрөгийн тэтгэлэг

91 Чадавхжсан
ТББ

21 Нөлөөллийн
санаачилга

18 ЖДБ-д чиглэсэн
судалгаа

3,258 Төрийн албан
хаагчид

- Барилгын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Гаалийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- ЖДҮХС-ийн журам, сонгон шалгаруулах аргачлал
- Хоршоо хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулах журам

ТӨСЛИЙН
ЭЦСИЙН ШАТНЫ
ҮНЭЛГЭЭ

96%
шаардлага
нийцсэн


Дундаж
4%

Чухал
16%

Маш чухал
80%

ТӨРИЙН
САНГУУДЫН ИЛ
ТОД БАЙДЛЫН
ҮНЭЛГЭЭ

101%
сайжирсан



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

Ажлын байр нэмэгдүүлэлт

2024 онд **560 ЖДҮ** шинээр **1,166 ажлын байр** бий болгосон бөгөөд хөдөө аж ахуйн салбар нийт **ажлын байрны 46%**-ийг бүрдүүлж, хамгийн том хувь нэмэр оруулав. Үүнээс гадна хөнгөн үйлдвэрлэл, барилгын салбарын бизнесүүд өсөлт үзүүлж, орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулав.

Борлуулалтын өсөлт

1,309 ЖДҮ борлуулалтын орлогоо нэмэгдүүлж, нийт **13 тэрбум төгрөг** (3.8 сая ам.доллар)-ийн өсөлт үзүүлэв. Үүний **65%-ийг хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбар** бүрдүүлсэн ба үйлдвэрлэл, чадамжийг нэмэгдүүлэх стратегийн дэмжлэгийн үр дүнд орон нутгийн бизнесүүдийн үйл ажиллагаа сайжирч, өрсөлдөх чадвар нь нэмэгдлээ.

ТӨСЛИЙН ХУГАЦААНД ДАРААХ ЧИГЛЭЛҮҮДЭД ТӨВЛӨРӨН АЖИЛЛАВ.

ГЭРЭЭ

КОВИД- ЦАХИМ
ШИЛЖИЛТ ЖДБ

БИЧИЛ ТЭТГЭЛЭГ
ОЛГОЖ ЭХЛЭВ.

2019

2020

2021



ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭН БАЙРШЛУУД

1. УЛААНБААТАР
2. ДАРХАН-УУЛ
3. ОРХОН
4. СЭЛЭНГЭ
5. ДОРНОГОВЬ
6. ЗАВХАН
7. ДОРНОД
8. ХОВД
9. БАЯНХОНГОР
10. ӨМНӨГОВЬ
11. ХЭНТИЙ
12. ХӨВСГӨЛ
13. ӨВӨРХАНГАЙ

ЭДИЙН ЗАСГИЙН
СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫГ
ЖДБ РҮҮ УЯЛДУУЛАВ.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЛБАРТ ТӨВЛӨРЧ
АЖИЛЛАВ.

ИМПОРТ ОРЛОХ САЛБАР
(Барилгын материал
үйлдвэрлэл, оёдол, хүнсний
ногоо)-Т ТӨВЛӨРӨВ.

2022

2023

2024






BEST ХӨТӨЛБӨР | ЗОРИЛТ 1-ИЙН ҮР ДҮН

ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх

BEST хөтөлбөр нь ЖДБ эрхлэгч, банк санхүүгийн байгууллага, төрийн байгууллага, ТББ зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих замаар зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлуудыг санаачлан хэрэгжүүлэхээс гадна зээлийн боловсрол олгох сургалт, зөвлөгөө, зээлд холбох үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Энэ зорилтын хүрээнд зөвхөн зээлд холбох үйлчилгээ үзүүлэхээс гадна бизнесийн менежментийг сайжруулах чиглэлээр бизнес төлөвлөгөө боловсруулах, санхүү бүртгэлээ сайжруулах, дижитал маркетинг, борлуулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэг сэдвүүдээр чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.



Зээлийн дүн, аймгаар


(тэрбум төгрөг)



Санхүүжүүлсэн эх үүсвэр (тэрбум төгрөг)




Хүйсийн харьцаа



Зээлийн дүнгийн өсөлт

(тэрбум төгрөг)



Санхүүжилтийн
хүртээмжийг
нэмэгдүүлэх зорилтын
үр дүнд нийт

5,397 ЖДБ-ийг
329.7 тэрбум
төгрөгийн зээлийн
санхүүжилт

авахад нь холбож,
дэмжлэг үзүүлэв.


56% Эмэгтэй
бизнесийн зээл

29% Хөдөө аж
ахуйн зээл

19% ЖДҮХСангийн зээл

16% Эдийн засгийг эрчимжүүлэх зээл

3% Хоршоо хөгжүүлэх сангийн зээл



ЖДҮГ, НЖДҮҮДТ, Хасбанк, Инвескор ББСБ зэрэг байгууллагуудтай хамтран хөнгөлөлттэй зээлд хамруулах зорилгоор зээлийн өмнөх болон дараах иж бүрэн санхүүгийн бус боловсрол олгох 34 удаагийн “Хурдасгуур” чадавхжуулах хөтөлбөрийг таван 7 хоногийн хугацаатай хэрэгжүүлж, **2,345 ЖДБ**-ийг хамруулсан. Тухайлбал “Эмэгтэй бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх” хурдасгуур хөтөлбөрийг нийт салбаруудын хэмжээнд хоёр удаа хэрэгжүүлсэн бөгөөд **631 ЖДБ** хамрагдаж, үүнээс **103 ЖДБ** **6,157,280,000 төгрөгийн зээл** авсан байна.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

BEST хөтөлбөрийн хүрээнд хүнс, арьс шир, оёдол, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын **1,316** ЖДҮ-ийг **111.9 тэрбум төгрөг** (33.1 сая ам.доллар)-ийн санхүүжилтэд хамруулж, хөгжлийг нь хурдасгалаа. Энэ нь бизнесүүдийг тоног төхөөрөмжөө шинэчлэх, бүтээгдэхүүний чанараа сайжруулах, импортоос хараат байдлаа бууруулахад чухал нөлөө үзүүлж, Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулав.

BEST ХӨТӨЛБӨР | ЗОРИЛТ 2-ЫН ҮР ДҮН

ЖДБ-ийн компанийн
засаглалыг сайжруулах



ЖДБ-үүдийн засаглалыг сайжруулах чиглэлд нийтдээ **1,000 орчим сургалтад 11,000 гаруй ЖДБ** хамрагдсан ба **1,288** харилцагч урт болон богино хугацааны зөвлөх үйлчилгээнд хамрагдаж, засаглалаа сайжруулсан байна.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд ЖДБ-үүдийн засаглалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, уулзалтуудыг түлхүү зохион байгуулсан ба 2 дахь жилээс ЖДБ-үүдийн засаглалын түвшинг үнэлж, түүнд суурилсан Олон Улсын Санхүүгийн Корпорац (IFC)-ын гарын авлагын дагуу засаглалын талаарх 5 төрлийн сургалтыг боловсруулж, ЖДБ-үүдийн засаглалыг сайжруулах урт болон богино хугацааны зөвлөх үйлчилгээнд хамруулан ажилласан бөгөөд шаардлагатай компанийн бичиг баримт, дүрэм, журамд сайжруулалт хийхэд туслалцаа үзүүлэн ажилласан.

ЖДБ-ЫН ЗАСАГЛАЛЫН

Гарын
авлага **9**

Жишиг дүрэм,
журам **34**

Богино хэмжээний
видео контент **40**

2022-2024 оны хооронд засаглалын зөвлөх үйлчилгээний үр дүнд BEST хөтөлбөрийн хэрэгжиж байгаа Улаанбаатар хот болон 12 аймагт **235 гишүүдийг** хамруулсан захирлуудын болон эмэгтэй бизнес эрхлэгчдийн клубүүд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Дөрвөн хүсэл ХХК нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг жижиглэнгийн дэлгүүрүүд бөгөөд өөрсдийн зах зээлийг томоохон сүлжээ дэлгүүрүүдээс хамгаалж, бараа материалынхаа татан авалтын өртгийг бууруулахын тулд байгуулагдсан компани юм. Анхлан 4 аймгийн 4 хувьцаа эзэмшигчтэй компани байсан бөгөөд хөтөлбөрийн компанийн засаглалын сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдсанаар компанийнхаа эрх зүйн байдал болон хувьцаа

эзэмшигчдийн эрх үүргийг тодорхой болгож, компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо, татан авалтын зардлын хэмжээ, хувьцаа эзэмшигч тус бүрийн ашгийн хэмжээгээ өсгөж чадсан юм. Тухайлбал, компанийн үйл ажиллагаа өргөжин 18 аймагт 23 хувьцаа эзэмшигчтэй болсон төдийгүй хувьцаа эзэмшигчдийн жилийн ашиг дунджаар 25 орчим хувиар нэмэгдэж, татан авалтын зардлыг 30 орчим хувиар бууруулан амжилттайгаар ажиллаж байна.



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

2024 онд BEST хөтөлбөрийн үр дүнд **443 ЖДҮ**-ийн засаглал сайжирч, **317** нь тусгай зөвлөх үйлчилгээ, **126** нь урт хугацааны менторингийн дэмжлэг хүртлээ. Энэ нь бизнесүүдийг албан ёсны үйл ажиллагаанд шилжих, ил тод байдлыг хангах, тогтвортой менежментийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд тусалсан. Мөн **2,700 гаруй ЖДҮ**-т сургалт явуулж, **5,380** оролцогчийг мэдлэг хуваалцах арга хэмжээнд хамруулав.

BEST ХӨТӨЛБӨР | ЗОРИЛТ 3-ЫН ҮР ДҮН

ЖДБ-ийн үйл ажиллагааг
дэмждэг төрийн болон төрийн бус
байгууллагуудын ил тод байдлыг
хангах, хяналтын тогтолцоог
бэхжүүлэх

Төрийн байгууллагын ил тод байдлыг сайжруулах хүрээнд АТГ, ХХААХҮЯ, ЖДҮГ, ЗБДС, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичгийг (МОУ) зурж, хамтын ажиллагаагаа илүү үр дүнтэй, хүртээмжтэй болгоход анхаарч, ЖДБ-ийг дэмжих чиг үүрэг бүхий ХХААХҮЯ, ЖДҮГ, ЗБДС болон бусад төрийн байгууллагуудын 3,258 албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байх сургалтад хамруулсан.

ТББ-ын нөлөөлөл, менежментийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор НӨЛӨӨЛЛИЙН ТҮҮЧЭЭ дэд хөтөлбөрөөр дамжуулан 146 ТББ, мэргэжлийн холбоодыг чадавхжуулсан. BEST хөтөлбөр нь ЖДБ-ийн экосистемийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд жил бүр төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, анхаарах зүйлс, цаашид шаардлагатай сайжруулалтуудыг тодорхойлох зорилгоор оролцогч талуудын хэлэлцүүлгийг өрнүүлсэн таван удаагийн форумыг зохион байгуулсан.

Түүнчлэн, орон нутгийн 12 салбарын хэмжээнд төрөөс олгогдож байгаа хөнгөлөлттэй санхүүжилтүүд болох ЖДҮХС, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хоршоо хөгжүүлэх сан зэрэг сангуудын ил тод, хүртээмжтэй байдлын үнэлгээг сүүлийн гурван жил дараалан гүйцэтгэсэн.

ТӨРИЙН БОЛОН ТББ-УУДЫН ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

146

Чадавхжуулсан ТББ,
мэргэжлийн холбоод

5

Форум

3,258

Авлига, ашиг
сонирхлоос ангид байх
сургалтад хамруулсан
албан хаагч





BEST хөтөлбөр болон ЖДҮГ-ын хамтын ажиллагааны үр дүнд АТГ-ын зүгээс хийгддэг төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээгээр ЖДҮГ нь 2022, 2023 онуудад 2 ба 1-р байранд тус тус эрэмбэлэгдэж, төрийн байгууллагуудад үлгэрлэл болж чадсан.

ЖДҮХС, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хоршоо хөгжүүлэх сан зэрэг сангуудын ил тод, хүртээмжтэй байдал 3 жилийн хугацаанд 101 хувь буюу 2 дахин сайжирсан.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд орон нутгийн 91 ТББ, мэргэжлийн холбоодыг тогтмол чадавхжуулан ажиллаж ирсэн. BEST хөтөлбөрийн хүрээнд чадавхжсан ТББ, мэргэжлийн холбоодын зүгээс бизнесийн орчныг сайжруулах, санхүүжилтийн механизмыг ил тод болгоход чиглэсэн нийт 21 нөлөөллийн санаачилгыг амжилттай хэрэгжүүлсэн.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

2024 онд **төрийн болон иргэний нийгмийн 3,100 гаруй төлөөлөгчийг** авлигатай тэмцэх, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр сургаж, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулав. Орон нутгийн захиргаад болон ТББ-уудын хамтын ажиллагааг сайжруулах зорилготой хэлэлцүүлэг, сургалтууд амжилттай зохион байгуулагдлаа.


2024 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ

BEST хөтөлбөр нь **“Өгөгдөлд суурилсан бодлогоор ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь”** сэдэвт форумыг зохион байгууллаа. Уг форумд оёдлын үйлдвэрлэл, барилын материал үйлдвэрлэл, хүнсний ногоо тариалалт болон хүнсний үйлдвэрлэлийн салбар хариуцсан төрийн байгууллага, ТББ, судлаачид болон ЖДҮ зэрэг **100 гаруй төлөөлөл** оролцож өгөгдөлд суурилсан бодлого, хамтын ажиллагаагаар ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулах талаар хэлэлцжээ. Монголын ЖДҮ-т тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэхэд оролцогч талуудын ажлын уялдаа, нягт хамтын ажиллагаа шаардлагатайг онцолсон.




BEST ХӨТӨЛБӨР | ЗОРИЛТ 4-ИЙН ҮР ДҮН

Бизнесийн хөгжлийн
стратегийг тодорхойлоход
чиглэсэн судалгааг хийх



BEST хөтөлбөрийн хүрээнд ЖДҮ-ийн секторт тулгараад буй асуудал, боломж, төр болон хувийн хэвшлийн уялдаа холбоог хэрхэн дэмжиж, ЖДБ-ийг хөгжүүлэх боломжтой талаар судлах зорилгоор нийт 18 удаагийн судалгааны ажлыг судалгааны хүрээлэнгүүдтэй хамтран гүйцэтгэсэн. Уг судалгаануудад Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн нийт 9,095 бизнес эрхлэгчдийг хамруулсан. Энэхүү 18 судалгааг ЖДБ-ийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв, чиг хандлага; Цар тахлын үеийн хүндрэл бэрхшээлийг даван туулах; ХАА-н бизнесийн хөгжил ба санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх; ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулах гэсэн 4 үндсэн чиглэлд багцлан гүйцэтгэснээр салбар бүрийн ЖДБ эрхлэгчид өөрсдийн бизнесийн хөгжил, дэвшилд шаардлагатай дата мэдээллийг нэг дороос авах боломжтой болсон.

ЖДБ-ийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв, чиг хандлага, бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор “ЖДБ-ийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал” судалгааг 2020, 2023 онуудад, “Албан бус эдийн засгаас албан эдийн засагт шилжилт: Сорилт ба Боломжууд” судалгааг 2023 онд тус тус гүйцэтгэсэн. Судалгаануудын үр дүнг нэгтгэн “ЖДБ-ийн хөдөлмөр эрхлэлт, албан эдийн засагт шилжих боломжууд” судалгааны эмхэтгэлийг ISBN дугаартайгаар гарган ЖДБ эрхлэгчдэд хүргээд байна.




ҮР ДҮН:

Судалгаануудын үр дүнд ЖДБ-үүдэд бизнесээ эрхлэхэд нь дэмжлэг болох бодлогын орчны ахиц дэвшлүүд гарсаар байна. Тухайлбал, 2024 онд **“Оёдлын салбарын нөхцөл байдлын судалгаа”**-г гүйцэтгэсэн ба судалгааны үр дүнд үндэслэн Оёдлын Салбарын Нэгдсэн Мэргэжлийн Холбоотой хамтран оёмол бүтээгдэхүүний үндсэн түүхий эд, дагалдах хэрэгслийн гаалийн татварыг тэглүүлэх хуулийн төслийг боловсруулсан. Уг хуулийг 2024 оны 5-р сард УИХурлаар амжилттай батлуулаад байна.



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН



2024 онд BEST хөтөлбөр нь импортыг орлох барилга, хүнсний ногоо болон оёдлын салбарын ЖДБ-үүдэд онцгойлон анхаарч ажилласан бөгөөд Монголын ЖДБ эрхлэгчид тэр дундаа импортыг орлох салбаруудын ЖДБ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг Олон Улсын Худалдааны төвийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг үнэлэх матрицан аргачлалаар үнэлсэн. Энэ үнэлгээнд үндэслэн Монгол Улсын ЖДБ эрхлэгчдийг жил бүр өрсөлдөх чадвараа үнэлж, бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэх, тогтвортой байдлаа хангахад нь туслах зорилгоор sme.dsmongolia.org цахим хуудсанд суурилсан **“ЖДБ-ийн өрсөлдөх чадварын судалгаа”**-ны платформыг хөгжүүлсэн байна.

BEST ХӨТӨЛБӨР | ЗОРИЛТ 5-ЫН ҮР ДҮН

Цаашид тогтвортой хөгжих боломжтой, санхүүжилт авах чадамжгүй төрийн бус байгууллага, гарааны болон жижиг бизнес эрхлэгчдэд бичил санхүүжилт олгох

BEST хөтөлбөр нь бичил тэтгэлгийн дэд хөтөлбөрийнхөө хүрээнд 176 орон нутгийн гарааны болон жижиг бизнесүүдэд нийт 1.7 тэрбум төгрөг (500,000 ам.доллар)-ийн санхүүгийн буцалтгүй дэмжлэгийг олгожээ. Энэхүү дэмжлэг нь орон нутгийн жижиг бизнесүүдэд санхүүгийн саад бэрхшээлүүдийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэж, хөдөө орон нутгийн ЖДБ-үүдийн 58-аас дээш хувьд хүрч ажиллаж, орон нутгийн эдийн засгийг


идэвхжүүлэхийн зэрэгцээ алслагдсан бүс нутгуудад ажлын байрыг олноор бий болгоход нөлөөлсөн байна. Үүнээс гадна BEST хөтөлбөр нь бизнес хоорондын хамтын ажиллагааг дэмжиж, бүс нутгийн хөгжлийн стратегийг боловсруулах, батлахад орон нутгийн засаг захиргаатай хамтран ажилладаг ТББ-уудыг бий болгож, хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа ч ЖДҮ эрхлэгчдэд үр ашгаа өгөх боломжийг бүрдүүлээд байна.

БИЧИЛ ТЭТГЭЛГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Тэтгэлгийн хэмжээ
(сектороор, сая төгрөгөөр)



Тэтгэлэг авсан аж ахуйн нэгжийн төрөл



Тэтгэлгийн хэмжээ болон үүссэн ажлын байр
(аймгаар, төгрөгөөр)





2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

BEST хөтөлбөр 12 аймгийн **43 бизнесийг** дэмжиж, нийт **423 сая төгрөг** (125,000 ам.доллар)-ийн санхүүжилт олгосон. Энэхүү тэтгэлэг нь орон нутгийн бизнесүүдийг хөгжүүлэх, шинэ зах зээлд гарах, бүтээгдэхүүнээ сайжруулах боломжийг бүрдүүлэв.


BEST ХӨТӨЛБӨР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЛБАРЫН ЖДБ-ИЙГ
ЧАДАВХЖУУЛАХ, ХӨГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019-2024

BEST хөтөлбөр нь орон нутгийн болон Улаанбаатар хотын салбарын харилцагч хүнс, ХАА-н бизнес эрхлэгчдийн бизнесийн засаглал, менежментийг сайжруулах, үйлдвэрлэл, бүтээмжээ нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь туслах **"ХҮНС, ХАА-Н БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ GREEN GROWTH", "GREEN LAB I, II, III"** хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэв. Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд зохион байгуулсан сургалт, зөвлөгөө, бизнес аялал, зээлийн зуучлал зэрэг үйлчилгээнд нийт **658** ЖДБ хамрагдаж, **405** ЖДБ бизнесийн засаглал, менежмент, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэгт амжилт гаргаж чадлаа.

ХҮНС, ХАА-Н САЛБАРТ



62 бизнес



3 ЖДБ



3 ЖДБ



69 ЖДБ

Дотоод аудиторууд бэлтгэв.



**ТӨРӨӨС ЗАРЛАСАН ОНЦЛОХ
ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ УЯЛДАЖ АЖИЛЛАВ.**



645

Хүнс, ХАА-н
бизнес

85

Хүнс, ХАА-н
бизнес

65.7

тэрбум төгрөг

836.6

сая төгрөг

ЗЭЭЛ

**ЖИЖИГ
ТЭТГЭЛЭГ**

38 ждб

Тохирлын
гэрчилгээтэй
болгов.

50 ждб

Шинэ
бүтээгдхүүн,
технологи
нэвтрүүлэв.



BEST ХӨТӨЛБӨР

ТӨСЛИЙН
ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ



BEST хөтөлбөр нь үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш оролцогч талуудыг татан оролцуулахад анхаарч ирсэн ба Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам, Жижиг Дунд Үйлдвэрлэл, Үйлчилгээний Газар, Зээлийн Батлан даалтын сан, Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газар, Авлигатай Тэмцэх Газрын Соён Гэгээрүүлэх хэлтэс, 12 аймгийн Засаг даргын

тамгын газар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд, 9 арилжааны банк, 4 банк бус санхүүгийн байгууллагуудтай санамж бичиг байгуулан үйл ажиллагаагаа уялдуулан жижиг, дунд бизнесүүдийг хөгжүүлэх чиглэлээр хамтарсан сургалт, уулзалтууд, хөгжүүлэх Хурдасгуур хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлж ирсэн.






ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

**ХУУЛЬ ЭРХЗҮЙ, БОДЛОГО
ЖУРМЫН ШИНЭЧЛЭЛ**
Барилгын тухай хууль, Гаалийн хууль, ЖДҮХСангийн журам, Хоршооны тухай хууль зэрэг ЖДБ-үүдэд ээлтэй орчныг бүрдүүлэв.

**ЗАХИРЛУУДЫН
КЛУБ**
Улаанбаатар хот болон 12 аймгийн 248 гишүүн бүхий бизнесийн нэгдлүүд бий болсон.

**САНХҮҮГИЙН БУС
ҮЙЛЧИЛГЭЭ**
Санхүүгийн байгууллагууд санхүүгийн бус үйлчилгээнд төвлөрөн ажилладаг болов. ЖДҮХС - Орон нутгийн төсөв зэрэг хамтарсан санхүүжилтийн сайн туршлагууд нэвтрүүлэв.

**ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮД-
ЗӨВЛӨХИЙН СҮЛЖЭЭ**
Нийслэлийн болон орон нутгийн ЖДҮ хөгжүүлэх мөрийн хөтөлбөрүүд, төлөвлөгөөг орон нутгийн удирдлагууд жил бүр гарган баталдаг болж, төслийн үр дүнд орон нутгийн чадавхжсан бизнес зөвлөхүүд, менторууд хамтран ажиллах боломжтой болов.



**МЭДЭЭЛЛИЙН
ИЛ ТОД БАЙДАЛ**
Орон нутаг бүрт төрийн байгууллагын ил тод байдлын үнэлгээ жил бүр хийгддэг болов. ТББ-ууд өөрсдөө оролцоогоо нэмэгдүүлэн, хэлэлцүүлэг, уулзалтууд зохион байгуулдаг туршлагатай болов.

**ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ**
Авлигаас ангид байх, Хоршоо Хөгжүүлэх сангийн төсөл үнэлэх аргачлал, ЖДҮХСангийн сонгон шалгаруулах үнэлгээ, гарын авлагуудтай болов.

**ЖДБ-ИЙН ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ПЛАТФОРМ**
Олон улсын аргачлалын дагуу онлайн платформд суурилан өрсөлдөх чадвараа үнэлэх боломжтой болов.

**СУДАЛГАА,
МЭДЭЭЛЭЛ, ГАРЫН
АВЛАГА**
Импорт орлох салбар, ХАА-н салбар, албан бус эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт зэрэг 14 судалгаа, мэдээлэлтэй болов.





2

**ЗАЛУУЧУУДЫН
БИЗНЕС
САНААЧИЛГА
(YOUTH
BUSINESS
MONGOLIA)
ХӨТӨЛБӨР
2013-2024**

YOUTH BUSINESS MONGOLIA ХӨТӨЛБӨР

2013-2024

YBM [Youth Business Mongolia]
хөтөлбөрийн зорилго:

Монгол Улсын 18-35
насны урам зоригтой,
хүсэл эрмэлзэлтэй бизнес
эрхлэгчдийг нийгэм, байгаль
орчинд ээлтэй замаар гарааны
бизнес, өсөлт, амжилт гаргахад
шаардлагатай дэмжлэгээр
хангах.

Youth Entrepreneurship Framework

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2013 онд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант улсад төвтэй Залуу Бизнесийн Олон Улсын Сүлжээ (Youth Business International (YBI)) байгууллагын итгэмжлэгдсэн гишүүн болсноор Залуучуудын Бизнес Санаачилга (Youth Business Mongolia (YBM)) хөтөлбөрийг эхлүүлсэн. YBI нь энтрепренер залуучуудыг дэмжих зорилгоор тогтвортой, хүртээмжтэй бизнес эрхлэх экосистемийг бий болгоход чиглэдэг. YBI-ийн 2023-2025 оны стратегийн хүрээнд 750,000 энтрепренер залуучуудыг дэмжих замаар нэг сая ажлын байр бий болгож, 250,000 бизнесийг шинээр эхлүүлэх, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Зорилтот бүлэг нь голчлон нийгэм, эдийн засаг, уур амьсгалын эрсдэлд өртсөн, ажилгүй эсвэл эмзэг нөхцөл байдалд байгаа залуус бөгөөд өөртөө болон бусдад зохистой, хүртээмжтэй, тохируулгатай ажлын байр бий болгох замаар орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй бизнесийн үйл ажиллагаа эрхлэх хүсэл тэмүүлэлтэй төлөөлөл юм.

Youth Entrepreneurship Framework

ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

1. ЭНТРЕПЕНЕР СЭТГЭЛГЭЭ, МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Энэхүү хөтөлбөр нь залуучуудын энтрепренерлэг сонирхлыг идэвхжүүлж, бие даан ажиллах чадварыг бий болгох зорилготойгоор боловсруулсан АРОЕ-НА загвараар явагддаг. Залуучууд итгэл үнэмшилтэй, урам зоригтой, нээлттэй болсны дараа бүтээлчээр сэтгэх, асуудлаа тодорхойлон шийдвэрлэх, хамтран ажиллах, түлхүүр ур чадвараа дадлагажуулах, шинэлэг үзэл баримтлал, стратеги, арга техникийг сурахад бэлэн байдаг. Тус арга барилын бусдаас ялгаатай тал нь хөтөлбөрт хамрагдагчдын сэтгэлгээ, мэдлэгийг хөгжүүлэх замаар суралцах үйл явцыг үр дүнтэй, хүртээмжтэй, жендер, хүний эрхийн мэдрэмжтэй байлгахад анхаардаг.



2. НОГООН, НИЙГМИЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нийгмийн энтрепренершип нь эерэг өөрчлөлтөөр нийгэм, байгаль орчны тулгамдсан асуудлыг үндсэн шалтгааны түвшинд хүртэл шийдвэрлэн аз жаргалтай ирээдүйг бүтээхэд чухал ач холбогдолтой. Бид энэхүү хөтөлбөрөөр ногоон болон нийгмийн энтрепренерүүдийг бизнесээ өргөжүүлэн, хөгжүүлэхэд нэн дэмжлэгтэй 30 гаруй хэрэглэгдэхүүнийг танилцуулан, үйл ажиллагаандаа бодитоор ашиглах арга барил, стратегийг хуваалцдаг.



3. МЕНТОРИНГ

2014 оноос хойш хэрэгжиж буй тус хөтөлбөр нь залуу бизнес эрхлэгчдэд өөрсдийн чадавхыг нэмэгдүүлэх, бизнесийн стратеги боловсруулах, мэдлэг ур чадвараа хөгжүүлэх онцгой боломж юм. Одоогийн байдлаар бизнес эрхлэлт, боловсрол, хөдөөгийн хөгжил, ногоон санхүүжилт болон ажил эрхлэлтийн чиглэлд зургаан менторингийн гарын авлагыг боловсруулан менторшипийн үйл ажиллагаануудад ашиглаж байна. Энэ хөтөлбөр нь аливаа салбар, чиглэлд туршлагатай ментор болон туршлага багатай менти хоорондын харилцан суралцах түншлэлийн загвар дээр тулгуурлан, бизнес эрхлэгч залуучуудын тодорхойлсон асуудлуудыг хамтран шийдвэрлэж, тэдний хөгжил болон амжилтад чиглэдэг. Ялангуяа 14-35 насны залуучуудад ажлын туршлагатай менторуудын зүгээс энтрепренершип сэтгэлгээ, бизнес төлөвлөлт, санхүүгийн мэдлэг, инновац, техник хөгжүүлэлт зэрэг чухал ур чадваруудыг хөгжүүлэхэд тусалдаг нь онцгой үр дүн бүтээдэг.



<p>Төслийн зорилтот харилцагч</p>	<p>НОГООН, НИЙГМИЙН БИЗНЕС</p> <p>186 Сургалт, уулзалтад оролцогч</p> <p>21 Бичил тэтгэлэгт хамрагдсан</p> <p>150 Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо</p>	<p>НИЙГЭМ, ЭВ НЭГДЛИЙН ЭДИЙН ЗАСАГ</p> <p>15 Сургалт, уулзалтад оролцогч</p>
<p>Ажил хайгч бус ажил олгогч болох хүсэл эрмэлзлээ ажил хэрэг болгон яваа 18-35 насны залуучууд</p>	<p>ЭНТРЕПРЕНЕРШИП СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨ</p> <p>2,114 Сургалт, уулзалтад оролцогч</p> <p>70 Шинэ бизнес</p> <p>349 Өргөжин сайжирсан бизнес</p> <p>1,824 Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо</p> <p>361 Зээлд хамрагдсан</p> <p>419 Нэмэгдсэн ажлын байр</p>	<p>МЕНТОРИНГ</p> <p>340 Сургалт, уулзалтад оролцогч</p> <p>70 Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо</p>

Нийт **21** харилцагчид **300,000** ам.долларын бичил тэтгэлэг авахад нь дэмжлэг үзүүлсэн.

Тэтгэлгээр тухайн харилцагчдыг бизнес загвараа нийгмийн болон ногоон болгох, бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хүрээлэн буй орчин тэр дундаа бэлчээр, ойн бүс, биологийн олон төрөл зүйлийг хамгаалах замд чиглүүлсэн.

Бэлчээрийн талбай:
300 га

Ойн талбай:
100 га

Дахин цуглуулсан хаягдал:
450 тн

ЗАЛУУ ЭНТРЕПРЕНЕР ОЛОН УЛСЫН БҮҮТКЭМП

Орон нутагт малчдын амьжиргааг, нөгөө талаас Улаанбаатар хотын зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд мал аж ахуйн түүхий эдийг байгальд хариуцлагатайгаар боловсруулах бизнес эхлүүлсэн залуу энтрепренер О.Ундрахгэрэл Залуу Бизнесийн Олон Улсын Сүлжээ (YBI)-ний бүүткэмпт Монгол Улсаа төлөөлөн оролцохоор шалгарсан. Тус арга хэмжээ нь Лондон хотод 2024 оны 6-р сард зохион байгуулагдсан бөгөөд дэлхийн 20 гаруй улсын залуус оролцсон.



НИЙГМИЙН ЭНТРЕПРЕНЕРҮҮДИЙН УУЛЗАЛТ

2024 оны 5-р сард жил бүрийн Нийгмийн Энтрепренерүүдийн Уулзалт зохион байгуулагдсан. Нийт 150 гаруй нийгмийн болон ногоон энтрепренерүүд оролцож, бодлогын болон олон нийтийн түвшинд өөрсдийн эрх ашиг, дуу хоолойг хүргэх талаар хэлэлцэв. Тухайн арга хэмжээний үр дүнд Монголын Нийгмийн Энтерпрайзуудын Холбоо байгуулагдсан. Цаашид Хөгжлийн Шийдэл ТББ нь тус холбооны гишүүн болсноор нийгмийн энтерпрайзуудыг албан ёсны хэлбэрээр бүртгэх, статистик бүртгэл үүсгэх, шаардлагатай санхүүжилтийн болон зах зээлийн боломжуудтай холбоход дэмжих ажлуудыг төлөвлөн бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

НОГООН БОЛОН НИЙГМИЙН ЭНТРЕПЕНЕР ЗАЛУУЧУУДЫГ ДЭМЖИХИЙГ УРИАЛАВ.



Бодлогын зөвлөмж:

Тогтвортой Хөгжлийн Зорилгуудад хүрэхэд энтрепренер залуучуудын ногоон болон нийгмийн бизнесийн загварыг урамшуулан дэмжих нь

2024 онд Залуу Бизнесийн Олон Улсын Сүлжээ (YBI)-ний дэмжлэгтэйгээр дэлхийд илүү олон залуучуудыг ногоон болон нийгмийн бизнесийг эхлүүлэх, өргөжүүлэхэд нь дэмжихийг уриалсан зөвлөмжийг Засгийн газар, санхүүгийн байгууллага, хөгжлийн байгууллагуудад зориулан боловсруулж, хүргэсэн.

Дэлхийн Эдийн Засгийн Форумын мэдээлснээр дэлхийд 10 сая орчим нийгмийн энтерпрайзууд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жил бүр ойролцоогоор 2 их наяд ам.долларын орлого олж, бараг 200 сая ажлын байр бий болгож байна. Энэ нь эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад ач холбогдолтойгоос гадна Тогтвортой Хөгжлийн Зорилгууд (ТХЗ)-д хүрэхэд амин чухал үүрэгтэй. Энтрепренер залуучуудын санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, зөвлөн дэмжих хүртээмж нь дэлхий даяар ихээхэн ялгаатай байгаа бөгөөд ялангуяа бага орлоготой орнуудад нийгмийн энтерпрайзуудын 15 хүрэхгүй хувь нь хангалттай санхүүжилт авах боломжоор хомс байна.

Ногоон болон нийгмийн энтрепренер залуучуудад тулгарч буй дээрх сорилтууд болон тэдэнд тохирсон дэмжлэг зайлшгүй шаардлагатай байгааг авч үзсэний үр дүнд, YBI нь Африк, Ази, Европ, Карибын тэнгисийн орнуудаас есөн гишүүн байгууллагуудтайгаа (энтерпрайзуудыг дэмжин хөгжүүлэгч) хамтран Ногоон болон Нийгмийн Энтрепренершипийн багц хэрэглэгдэхүүнийг боловсруулан танилцуулсан. Энэхүү багцыг ногоон болон нийгмийн энтрепренерүүдийг дэмжихэд юу болж, юу болохгүй байгаа тал дээр YBI болон гишүүдийн мэдлэг, туршлагаар баяжуулан хөгжүүлж, энэ чиглэлээр дэмжлэг үзүүлэх сонирхолтой энтерпрайзуудыг дэмжигч байгууллагуудад (ESOs) зориулсан. Дөрвөн тивийн YBI-ийн гишүүдтэй хамтран бүтээсэн уг багцыг янз бүрийн улс орны нөхцөлд ажиллаж буй ногоон болон нийгмийн энтрепренер залуучуудад байнгын хэрэгцээтэй, ашиглагдахуйц байлгахад анхаарсан.

Энэхүү багцад доорх зургаан үндсэн чиглэлийн хэрэглэгдэхүүн, ашиглах зааврыг эмхэтгэн оруулсан.

- Нийгмийн энтрепренерийн хувь хүний хөгжил
- Нийгмийн болон ногоон бизнесийн санаа
- Бизнесийн загвар
- Бизнесийн баталгаажуулалт
- Хууль эрх зүйн болон санхүүгийн тогтолцоо
- Нөлөөллийн хэмжилт

“Тогтвортой Хөгжлийн Зорилгуудад хүрэхэд энтрепренер залуучуудын ногоон болон нийгмийн бизнесийн загварыг урамшуулан дэмжих нь” бодлогын зөвлөмжийг бүрэн эхээр нь www.dsmongolia.org цахим хуудаснаас олж унших боломжтой.

**“Хүн бүр хариуцлагатай байвал
бид илүү хүнлэг, эрүүл, ээлтэй
ирээдүйг хамтдаа бүтээнэ.”**

Д. Энхтуул

НИЙГЭМД ЭЭЛТЭЙ АМЬТНЫ ЭМНЭЛЭГ

Багаасаа амьтанд хайртай охин байсан би өдгөө гэр бүлийн хамт “Хатан Сэврэй” нэртэй жижиг амьтны эмнэлгээ амжилттай ажиллуулж байна. Манай сум 840 гаруй нохой тэжээгчтэй, хэрэгцээ ихтэй байгааг анзаарч, 2021 оны 9-р сард өөрийн туршлага дээр тулгуурлан эмнэлгээ нээсэн. Манай эмнэлэг нохой, муурны үзлэг, эмчилгээ, үржил хаах мэс ажилбар, зөвлөгөө өгөхөөс гадна иргэдэд хариуцлагатай тэжээх талаарх сургалт зохион байгуулдаг.

Монгол Улсад гэрийн тэжээвэр амьтны тухай хууль 2023 онд батлагдсан нь бидний үйл ажиллагааг улам бататгасан. Золбин амьтдын тоо буурах, өвчлөл, хөрсний бохирдлыг багасгах, хотын өнгө үзэмжийг сайжруулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд манай бизнес оролцож байна.

2023 онд Хөгжлийн Шийдэл ТББ болон Youth Business Mongolia-ийн ногоон ба нийгмийн бизнесийн сургалтад хамрагдаж, бизнесийн загвараа шинэчлэн тодорхойлж, илүү үнэ цэнтэй үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Сургалтын үр дүнд бизнесээ төлөвлөх, зорилгоо тодорхойлох, иргэдэд мэдээлэл түгээх арга барилаа сайжруулсан.



**НИЙГМИЙН БА НОГООН
БИЗНЕСИЙГ НУТАГТАА
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
МАЛЫН ЭМЧ**

ИРЭЭДҮЙД БИД:

- Явуулын амьтны эмнэлгийн машинтай болох
- Хөдөө сумдын иргэдэд үйлчилгээ хүргэх
- Малын эмчийн сургалтын төв, амьтны асрамжийн газар байгуулах зорилготой.





3

**ОРОН
НУТГИЙН
ХӨДӨӨ
АЖ АХУЙН
БИЗНЕСИЙГ
ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР
2019-2024**

ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн Бизнесийг Дэмжих хөтөлбөрийг Оюу Толгой ХХК-ийн санхүүжилтээр Өмнөговь аймгийн Ханбогд суманд амжилттай хэрэгжүүлж дууссан.

Хөтөлбөрийн зорилго:

- Ханбогд суманд хэрэгжүүлж буй төсөл, иргэд, малчдад зориулсан дэмжлэгүүдийн хоорондын уялдааг сайжруулах;
- Төсөл, дэмжлэгүүдийг Ханбогд сумын болон Өмнөговь аймгийн бодлоготой уялдуулах;
- Оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах;
- Ханбогд сумын малчид, иргэдийн амьжиргааг сайжруулах;
- ХАА-н салбарын тогтвортой хөгжлийг бий болгох.

ӨМНӨХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЧАДАВХ

165,527	9
Мал сүрэг	Малчдын хоршоо
380	2
Малчин өрх	Хүнсний ногооны хоршоо

СОРИЛТУУД

- Бизнес эрхлэх ур чадвар, хамтын ажиллагаа сул;
- Байгалийн өндөр эрсдэлтэй мал аж ахуй;
- Хүнсний аюулгүй байдал хангах болон хянах тогтолцоо сул;
- ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжөөгүй, бүтээмж сул, улирлын чанартай орлогоос бүрдсэн.

ОРОН НУТГИЙН МАЛ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ: “ХАНБОГД СУМЫН ТУРШИЛТЫН ТӨСӨЛ”

АЛСЫН ХАРАА: Тогтвортой, өрсөлдөх чадвартай, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх замаар орон нутгийн эдийн засаг, хүнсний аюулгүй байдлыг хангах, хүлэмжийн хий болон CO2-ыг бага хэмжээгээр бууруулахад хувь нэмрээ оруулах.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД :

1. Засаглал, тогтолцоог сайжруулах - Ханбогд МАА-н эрүүл мэндийн төв, ариун цэврийн лаборатори
2. Тогтвортой ханган нийлүүлэгчдийг бий болгох - Ангус үхрийн мах, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ноолуур, Гавилууд хонин сүрэг, ингэний сүү
3. Нэмүү өртгийн үйлдвэрлэл бий болгох - Мах, сүүний үйлдвэр
4. Зах зээл, ложистикийг хөгжүүлэх - Малчдын зах, борлуулах төвүүд

ХОЛБОГДОХ БИЧИГ БАРИМТУУД :

- 3 талт зөвлөл
- Өмнөговь аймгийн ХАА-н салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- Тогтвортой ноолуур, Бэлчээр хамгаалал зэрэг бичиг баримтуудтай уялдаа хангах
- Оюу Толгой ХХК-ийн холбогдох албадуудын журмууд

ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛУУД :

- ХХААХҮЯ, орон нутгийн захиргаа: Бодлогын дэмжлэг
- 3 талт зөвлөл: Зөвлөмж
- Ханбогд сумын малчид, бүлэг хоршоод: Үйлдвэрлэл
- Оюу Толгой ХХК: Боломжит худалдан авагчдыг холбох
- Хөгжлийн шийдэл ТББ (дотоод), Business for Development (Австрали), бусад ТББ-ууд, Даланзадгад ВIG төв, ХААИС- зөвлөх үйлчилгээ, сургалт, хөгжүүлэлт, хяналт мониторинг
- Говийн Оюу ХДС, НҮБ болон олон улсын донор байгууллагууд: Санхүүжилтийн Түншлэл
- Элчин сайдын яамдууд (Хятад, ОХУ, Канад, Австрали, АНУ): Partners-туршлага, холбоо сүлжээний түншлэл

ХҮРЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЗОРИЛТОТ ҮР ДҮН

Ханбогд сум -
Тогтвортой, даван
туулах чадвартай
олон талт эдийн засаг
болон бүрдүүлэгч
бүлгүүд бий болох

Байгальд ээлтэй
хүртээмжтэй ХАА-н
хөгжил

Хүнсний аюулгүй
байдал сайжрах

Зах зээлд суурилсан
мал аж ахуй

Оюу Толгой ХХК-
ийн орон нутгийн
худалдан авалтад:
> 40% (2026)

ХӨТӨЛБӨРИЙН ТООН ҮР ДҮН

Орон нутгийн МАА-н
бизнесийг дэмжих
хөтөлбөр 2019-2024
он хүртэл хэрэгжиж,
дараах онцлох үр
дүнд хүрэв.

412

Хамрагдсан малчин
өрх

11

Байгуулагдсан аж
ахуйн нэгжүүд

6

Амжилттай
хэрэгжсэн төсөл

70+

Бий болсон ажлын
байр

498

Сургалт, уулзалт

3,593

Хамрагдсан хүний
тоо

244

Зөвлөх үйлчилгээ

1,336

Хамрагдсан хүний
тоо

280+

Боловсруулсан
бичиг баримт

30+

Боловсруулсан төсөл
хэрэгжих боломжийн
судалгаа

12.7 сая

Нэг малчин өрхөд
ногдох хөрөнгө
оруулалтын хэмжээ

700 сая


Оюу Толгой ХХК руу
ханган
нийлүүлэлт

1.5 тэрбум

Малчдын амьжиргаа
дэмжих төслүүдийн
өөрийн хөрөнгө

ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019



Мал нядалгааны зам, малчны зах төслүүдийн засаглалын хувилбарыг боловсруулж, Оюу Толгой ХХК-ийн ОНХХ, Гурван талт зөвлөл болон нийт малчдад танилцуулсан. LASS хөтөлбөрийн таван жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Малын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулж, шинээр таван орон тоог баталгаажуулсан.

2020




Оюу Толгой ХХК-ийн Зудын эрсдэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн. Малчны зах, мал нядалгааны зам төслүүдийн засаглалын хувилбарыг бүх малчдаас сонгуулах ажлын хүрээнд дөрвөн багийн хурлыг зохион байгуулж, үр ашигтай хувилбарыг нийт малчдын саналаар сонгосон.

2021




Багуудын анхан шатны хоршоо байгуулах ажлын хүрээнд малчдад сургалт зохион байгуулах ажлуудыг хийж, бэлтгэл ажлыг хангасан. Мал нядалгааны замын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулахтай холбоотой бэлтгэл ажлуудыг зохион байгуулж, ТЭЗҮ боловсруулах ААН-үүдийг шалгаруулж, ТЭЗҮ-ийн материал хүлээж авсан.

2022



Багуудын анхан шатны хоршоо байгуулах ажлыг зохион байгуулж, дөрвөн баг дээр дөрвөн анхан шатны хоршоог амжилттай байгуулсан. Эрүүл малчин хөтөлбөрийн хүрээнд малчдыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлын худалдан авалтыг хийж, 412 малчин өрхийн гишүүдийг хамруулсан. LASS хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотойгоор Мах, Сүү, Ногооны стратеги боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Малчдын хоршооны ил тод байдлыг сайжруулах зорилгоор МАЛЧИН аппликэйшнийг хөгжүүлж, ашиглалтад хүлээн авсан. Ханбогд сумын ногоо, мах, сүүний салбарын стратеги төлөвлөгөө боловсруулсан.

2023



МАДТөслийн хүрээнд шинээр гахайн аж ахуй, аж ахуйн үйлчилгээ үзүүлэх төсөлд зөвлөгөө өгсөн. Малчны зах, мал нядалгааны зам төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дундын хоршоо байгуулах хурлыг зохион байгуулж, Галбын Говийн Торгон сүрэг дундын хоршоог байгуулахад техникийн туслалцаа үзүүлсэн. "Нэг Сум - Нэг Хоршоо" зөвлөгөөнийг 2023 оны 4-р сарын 25-ны өдөр Өмнөговь аймгийн Ханбогд суманд амжилттай зохион байгуулахад арга зүйн туслалцаа үзүүлсэн. Оюу Толгой ХХК-иас Ханбогд, Манлай, Баян-Овоо сумын малчдын зудын эрсдэлийг бууруулах зорилгоор өвс тэжээлийг судлах, тээвэрлэх, худалдан авалт буулган хүлээлгэн өгөх ажлыг амжилттай зохион байгуулсан. Өмнөговь аймгийн Зүүн бүсийн хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, бизнесийн туршлага судлах аялалыг амжилттай зохион байгуулсан.

2024



МАДТ-ийн хэрэгжүүлэгчдэд зориулсан тогтвортой байдал, хаалтын төлөвлөгөөг боловсруулж, Оюу Толгой ХХК-ийн ОНХХ болон төсөл хэрэгжүүлэгч малчдын төлөөлөлд танилцуулж, хүлээлгэн өгсөн. Галбын Говийн Торгон сүрэг дундын хоршоонд шаардлагатай менежментийн бичиг баримтын багцыг бүрдүүлж, ОНХХ болон дундын хоршооны удирдлагад хүлээлгэн өгсөн. Малчдын амьжиргаа дэмжих шинэ санаачилгыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 27 малчны 11 санаачилгыг хөгжүүлсэн.



2024 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ

Орон нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн тогтвортой, хүртээмжтэй ХАА-н бизнесүүдийг хөгжүүлэх зорилгоор Оюу Толгой ХХК-ийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлж буй төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.

Байршил: ХАНБОГД СУМ

	Малчдад чиглэсэн сургалт, уулзалт	Бусад сургалт, уулзалт	Зөвлөх үйлчилгээ	Боловсруулсан бичиг баримт	Нийт
Оролцогчийн тоо	45	30	121	16	167
Зохион байгуулсан тоо	3	15	21	19	55

100 сая төгрөг

Нийт борлуулалтын орлогын өсөлт

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мал аж ахуй эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор тухайн бизнестэйгээ уялдуулан Ханбогд сумын хэрэглээнд тохируулан дараах төслүүдийг хэрэгжүүлэхээр 1-3 хүртэл малчидхамтрандонор байгууллагаас санхүүжилт татаж, төслийн бэлтгэл ажлаа ханган ажилласан байна.

Үүнд:

- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Ногоон тэжээл тариалалт
- Хүлэмжийн аж ахуй-Ногоо тариалалт
- Малын өөхөөр гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Ямааны сүүний аж ахуй байгуулах зэрэг төслүүд болно.

Энэхүү төслүүдийн хэрэгжих боломжийн судалгаа, бизнес төслийг Хөгжлийн Шийдэл ТББ боловсруулж, донор байгууллагад төслөө танилцуулах, санхүүжилтээ батлуулахад нь чиглүүлж ажилласан. Төслүүд хэрэгжсэнээр 10-аас доошгүй ажлын байр бий болж, Ханбогд сумын өсөн нэмэгдэж буй хүн амын хэрэглээнд чанартай бүтээгдэхүүнүүд нийлүүлэгдэх юм.







4

**“ЭДИЙН
ЗАСГИЙН
НОГООН
ШИЛЖИЛТ”
SOGЕ ТӨСӨЛ
2022-2025**

“ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ”

SOGE ТӨСӨЛ

2022-2025

Хөгжлийн Шийдэл ТББ нь Европын Холбооны Свич-Эйшиа хөтөлбөрийн хүрээнд **Монгол Улсын нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй тойрог эдийн засагт шилжих, улмаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготойгоор** Пийпл ин Нийд ОУТББ, Каритас Чех Репаблик ОУТББ, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС) болон Хөгжлийн Шийдэл ТББ хамтран **Улаанбаатар хот, Эрдэнэт, Сэлэнгэ аймгуудад** Эдийн Засгийн Ногоон шилжилт төслийг хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд Монгол Улсын хөдөө аж ахуйн хүнс, ус, ундаа үйлдвэрлэлийн салбарын бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч, борлуулагчдыг дадал, зан төлөвөө өөрчлөхөд шаардлагатай мэдээлэл, аргачлалаар хангах, улмаар зах зээлд суурилсан эко шошгыг нэвтрүүлж, ногоон санхүүжилтийн эх үүсвэртэй болох, цаашлан “Тойрог эдийн засаг”-т шилжихэд нь дэмжлэг үзүүлэх юм.

Хөгжлийн шийдэл ТББ нь төслийн 2-р зорилтын хүрээнд ХАА-н болон шингэн хүнсний салбарын БЖДҮ болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд бүтээгдэхүүндээ ногоон шошгыг нэвтрүүлж, тойрог эдийн засаг, нэмүү өртгийн сүлжээний ногоон практикийг нэвтрүүлэхэд мэдлэг, мэдээллээр хангах сургалт, уулзалтуудыг зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллаж байна.



Нийт
санхүүжилт:

Салбарын
байршил:

**2.2 САЯ
ЕВРО**


**Улаанбаатар
Эрдэнэт
Сэлэнгэ**

Төслийн зорилтот харилцагч:

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИД




Сургалтад хамрагдсан оролцогчид: Нийт 878 хүн




450
оролцогч

Улаанбаатар:
8 удаагийн сургалт




180
оролцогч

Эрдэнэт:
3 удаагийн сургалт



128
оролцогч

Налайх & Багануур:
2 удаагийн сургалт



120
оролцогч

Сэлэнгэ:
2 удаагийн сургалт





2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

“Эдийн засгийн ногоон шилжилт” (SOGE) төсөл нь хөдөө аж ахуйн гаралтай хүнс, ус, ундааны салбарын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид болон жижиглэн худалдаа эрхлэгчдийг хэрхэн тойрог эдийн засагт шилжих, байгаль орчинд ээлтэй, ногоон бизнесийн чиглэлээр мэдлэг, мэдээлэлтэй болгох зорилготойгоор “Хурдасгуур хөтөлбөр”-т хамруулдаг. Хөтөлбөрт оролцогч БЖДҮ эрхлэгчид бизнесээ ногоон, тогтвортой болгож сайжруулахын тулд хог хаягдлыг зайлуулах, дахин боловсруулах менежмент, эрчим хүчний хэрэглээг бууруулах, усны менежмент, хүнсний хог хаягдлыг багасгах, хүнсний тогтвортой сав баглаа боодол, хямд өртөгтэй зээл болон санхүүгийн бүтээгдэхүүний баримт бичгийг бэлтгэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх зэрэг өргөн хүрээний сэдвүүдээр мэдлэгтэй болсон байна. Төслийн хүрээнд Хөгжлийн шийдэл ТББ нь нийт **900 бизнес эрхлэгчдийг** хөтөлбөрт хамруулахаас 2024 оны 12-р сарын байдлаар **725 орчим бизнес эрхлэгчдэд** тойрог эдийн засаг болон төслийн талаар мэдээллийг хүргэсэн.

Хурдасгуур хөтөлбөрийн дараагийн шатны уулзалт болох менторшипийн уулзалт нь бизнесээ тойрог эдийн засагт шилжүүлэх, байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх хүсэлтэй оролцогчдод хэрхэн, ямар арга замаар гэх зэрэг чиглүүлэх зорилготой зохион байгуулагддаг. Төслийн хүрээнд **420 бизнес эрхлэгчтэй** энэхүү уулзалтыг хийхээс 2024 оны 12-р сарын байдлаар **148 орчим оролцогчдод** чиглүүлэх менторшипийн уулзалт хийсэн байна.

ЭКО ТЭМДЭГЖҮҮЛЭЛТИЙН ТОГТОЛЦОО БА СТАНДАРТЫН ХЭРЭГЛЭЭ

Г.Болормаа / ТоС Холбооны Стандарт, баталгаажуулалтын менежер



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЕВРОП РУУ ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд 2024 оны 6-р сард ХБНГУ болон Швейцар улсуудад БОНЗ үнэлгээ, бүтээгдэхүүний эко тэмдэг, баталгаажуулалтын талаарх олон улсын шилдэг туршлагуудтай танилцаж, хөтөлбөрийг амжилттай зохион байгуулсан. Туршлага судлах аяллаар хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгчдийн төлөөллүүд ЕХ-ны Ногоон Хэлэлцээр, таксономи, тогтвортой байдлын стандарт, бүтээгдэхүүний байгаль орчны чанарын тэмдэг, баталгаажуулалтын процесс зэрэг сайн туршлагуудтай танилцсан. Мөн байгаль орчинд ээлтэйгээр бизнесээ эрхэлдэг ногоон био маркетууд, шингэн хүнс болон хүнсний үйлдвэрийн газруудтай танилцсан.

Төслийн хүрээнд хамтран ажиллаж, туршлага судлах аяллын багийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагыг төлөөлж Монгол банк, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам, Стандарт Хэмжил Зүйн Газар, Үндэсний Итгэмжлэлийн Төв оролцож, мөн "Монголын Хүнсчдийн Нэгдсэн Холбоо" ТББ, хүнс, ус ундааны үйлдвэрлэлийг төлөөлж "Апу Дейри" ХХК, "М-Си-Эс Кока-Кола" ХХК, "ЭмЖиЭл Акуй" ХХК, "Еден" ХХК, "Гүүд Фүүдс" ХХК, Орхон аймгаас "Ранчо" ХХК, Сэлэнгэ аймгаас "Сэлэнгэ Таван Хайрхан Хоршоо", худалдааны байгууллагыг төлөөлж "И-март" ХХК, "Централ Экспресс" (СУ) ХХК зэрэг төр болон хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн өргөн бүрэлдэхүүнтэй оролцсон.







БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



5

МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ БА НОГООН БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛД БЖДБ ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ТӨСӨЛ

2023-2025

МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ БА НОГООН БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛД БЖДБ ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ТӨСӨЛ

2022-2024

Хөгжлийн Шийдэл ТББ нь эдийн засгийн загварыг Монгол Улсын аялал жуулчлалын салбарт нэвтрүүлэх, Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалга, Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр “Тойрог эдийн засаг (ТЭЗ) ба ногоон бизнесийн чиглэлд БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ чадавхжуулах” зөвлөх үйлчилгээг IRIM, ToC Холбоотой хамтран 2022 оны 11 сараас 2024 оны 05 сарын хугацаанд хэрэгжүүлсэн.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН

350 гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд “Шилдэг ногоон санаачилга” төслийн тэтгэлэгт уралдаан зарлагдсан бөгөөд тус уралдаанд шалгарсан шилдгийн шилдэг 16 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд тус бүр 10,000 ам.доллар хүртэлх буцалтгүй тусламжийн тэтгэлгийг Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам болон Азийн Хөгжлийн Банкны төлөөлөл гардуулан өгсөн.



Байршил:

УЛААНБААТАР, ХӨВСГӨЛ, АРХАНГАЙ

Уг төсөл нь аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг эмэгтэй эзэнтэй болон эмэгтэй удирдлагатай БЖДБ эрхлэгчдийг COVID-19-ийн дараах хямралаас бизнесээ сэргээж, тогтвортой ногоон сэргэлтийг хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах 3 бүрэлдэхүүн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Тойрог эдийн засгийг дэмжсэн бодлогын орчин, хууль эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, тойрог эдийн засгийг нэвтрүүлэх боломж, хүндрэл бэрхшээлийн талаар цогц үнэлгээ хийх;
2. Судалгааны үр дүнд үндэслэн зорилтот салбарын БЖДБ эрхлэгчдийн тойрог эдийн засгийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт, чадавх бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
3. Чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн үр дүнд суурилан үндэсний болон олон улсын түвшинд бий болсон үр дүнгийн талаарх мэдээлэл түгээх, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах юм.

ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ:

СУРГАЛТЫН ТӨРӨЛ:

Танхимын
сургалт:

421 хүн
хамрагдсан.

Онлайн
сургалт:

360 ЖДҮ
оролцсон.
(3 бүс нутгаас)

НИЙТ ОРОЛЦОГЧИД:

421 эмэгтэй бизнес
эрхлэгчид

221
Улаанбаатар

200
Хөвсгөл,
Архангай

Амжилмыг ТҮҮХ

Гэр бүлийнхээ амьжиргааг дээшлүүлэхээр Б.Туяа БНСУ-д таван жил ажилласан бөгөөд буцаж ирэхдээ ирээдүйнхээ талаар тодорхойгүй байв. Гэвч түүний эрүүл мэндийн бүтээгдэхүүний үйлдвэрт ажилласан гурван жилийн туршлага нь шинэ санаа бүхий бизнес бий болгох боломжийг олгож, 2017 онд тэрээр "Ногоодой" нэрийн таван төрлийн эрүүл мэндийн шүүсийг үйлдвэрлэж эхэлжээ.

Үйлдвэрлэлийн туршлагатай ч компанийн засаглал, бүтээгдэхүүний хөгжүүлэлт, санхүүгийн менежмент зэрэг чухал чиглэлүүдэд мэдлэг дутмаг байсныг тэрээр нуусангүй. Энэхүү дутагдлаа нөхөхийн тулд тэрээр Хөгжлийн Шийдэл ТББ-ийн сургалтуудад хамрагдсан бөгөөд өглөө бүр 04:00 цагт үйлдвэртээ ажиллаж, 09:00 гэхэд сургалтад оролцдог байв. Хичээл зүтгэлийн үр дүнд бизнес төлөвлөгөөгөө сайжруулж, ЖДҮ-ийн зээлд хамрагдаж чадсан байна.

Зээлийн хөрөнгөөр түүхий эдийн нөөцөө тогтворжуулж, цар тахлын үед үйл ажиллагаагаа тасалдуулалгүй үргэлжлүүлж, орлогоо нэмэгдүүлжээ. Б.Туяагийн хувьд бизнесийн гол зарчим бол хариуцлага. Нэгэн удаа хэрэглэгч захиалсан шүүснээс нэг ширхэг дутуу ирсэн тухай гомдол гаргахад тэр өөрийн биеэр очиж хүргэж өгсөн бөгөөд энэ нь тухайн хэрэглэгчид гүн сэтгэгдэл үлдээж, улмаар томоохон захиалга ирэх үндэс болсон юм. Үүний дараа бүтээгдэхүүнээ лацжуулж, чанарын хяналтыг улам сайжруулжээ. Тэрээр мөн "Эдийн засгийн ногоон шилжилт" (SOGЕ) төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалт, менторшип хөтөлбөрт амжилттай оролцсон бөгөөд мөн АХБ-ны дэмжлэгтэй "ЖДҮ-үүдийн чадавх бэхжүүлэх" төслийн хүрээнд төсөл бичиж өрсөлдөн 9000 ам.долларын буцалтгүй санхүүжилт авч, байгальд ээлтэй тоног төхөөрөмж худалдан аван үйлдвэрлэлээ тойрог эдийн засгийн зарчимд шилжүүлж эхэлжээ.

Түүний амьдралыг чиглүүлсэн хоёр чухал зарчим бол: БНСУ-д ажиллаж байхдаа үйлдвэрийн эзнээс сонссон "Өрсөлдөөн хөршөөсөө эрт босохоос эхэлдэг" гэх үг болон эмээгийнх нь хэлдэг байсан "Аливааг цагт нь хүргэж сур" гэх зөвлөгөө юм. Б.Туяа 74 сарын турш түрээсээ хугацаандаа төлж, ЖДҮ-ийн зээлээ ч хугацаанд нь тууштай төлж байгаа нь дараагийн бизнесийн боломжуудыг нээж өгнө гэж тэр үздэг.

Хариуцлагатай, үнэнч байдлыг нь үнэлэн Монгол Улсын Ерөнхийлөгч үйлдвэртэй нь танилцсан бөгөөд түүнийг хариуцлагатай бизнес эрхлэгчийн үлгэр дуурайл болсон хэмээн онцолжээ.

Цаашид "ТИНЦ" ХХК нь байгальд ээлтэй, органик, дахин боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрлэгч болох зорилго тавьж байгаа бөгөөд SOGE болон АХБ-ны төслүүдийн оролцоо чухал нөлөөтэй байсныг Б.Туяа онцолдог.



"Би бүтээгдэхүүндээ яг л хүүхэд шиг ханддаг, тийм их хайртай" "Ногоодой" нэрийн шүүс үйлдвэрлэгч Б.ТУЯА

СУРГАЛТЫН АГУУЛГА:

ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

УСАН ХЭМНЭЛТИЙН СТРАТЕГИ

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БА БАГАСГАЛТ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТ

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ САВ, БАГЛАА БООДОЛ





ГЭР БҮЛ,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



6

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ
ХАРИЛЦАГЧ

Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны Хөдөлмөр Эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд жижиг болон гарааны бизнес эрхлэгч залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, ажил хайгч иргэдийг ажилтай, орлоготой болгоход дэмжих, чадавхжуулах зорилготой юм.

ГАРААНЫ
БИЗНЕС
ЭРХЛЭГЧ
18-34 НАСНЫ
ЗАЛУУЧУУД

ЖИЖИГ БИЗНЕС
ЭРХЛЭГЧ ИРГЭД,
АЖ АХУЙН НЭГЖ,
ЭМЭГТЭЙЧҮҮД,
ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭД

2024 ОНЫ ҮР ДҮН

	Аж ахуй эрхлэлтийн сургалт	СТАРТ АП	Бусад гэрээт үйлчилгээ
Сургалт, уулзалт	40	28	20
Сургалт, уулзалтад оролцогч	649	72	455
Зөвлөх үйлчилгээ		22	235
Байгууллагад орсон орлогын хэмжээ	21,960,000	30,000,000	69,920,500

2024 онд Улаанбаатар хот болон Баянхонгор, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий аймгийн ХХҮГазруудтай хамтран нийт 743 иргэн, аж ахуйн нэгжийг бизнес эрхлэлтийн болон гарааны бизнесийн сургалт, зөвлөгөөнд хамруулж, ХЭДСангаас 262 бизнесийг 2.6 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт авахад нь дэмжлэг үзүүлж ажилласан.



“АМЖИЛТ БОЛ СОНГОЛТ” эмэгтэйчүүдийн форум

Чингэлтэй дүүргийн ЗДТГ болон ХХҮХэлтэстэй хамтран “Амжилт бол Сонголт” эмэгтэйчүүдийн форумыг Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяны хүрээнд зохион байгуулсан. Манай улсад анх 1997 оноос эхлэн Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвөөс энэхүү аяныг зохион байгуулж иржээ.

Форум нь Чингэлтэй дүүргийн эмэгтэйчүүдэд амьдралын хэв маягаа сайжруулж өөрчлөх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, найзалж нөхөрлөх, идэвхтэй хөгжих боломжуудыг танилцуулах замаар урам зориг өгч, идэвхжүүлэх зорилготой. Форумд **250 гаруй эмэгтэйчүүд** оролцож, Чингэлтэй дүүргийн ЗДТГ, ХХҮХ-ээс эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого чиглэлүүд, цаашид хийх нөлөөллийн ажлууд болон эмэгтэйчүүдэд урам зориг өгөх илтгэлүүд хүлээн авч, санал сэтгэгдлээ хуваалцлаа.

Мөн форумын үеэр “Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй- Шалтаг бүү тооч” уриан доор хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг холбогдох байгууллагуудаас өгч ажиллав.



ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ТҮНШЛЭЛ



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



ГЭР БҮЛ,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРГЭХҮҮВЧ АГЕНТЛАГ
ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАР



ЗАСГИЙН ГАЗРЫН
СЭРГЭЭГЧЛЭГЧ АГЕНТЛАГ
ТАТВАРЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРГЭХҮҮВЧ АГЕНТЛАГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗАР



АВЛИГАГҮЙ НИЙГМИЙН
ТӨЛӨӨ ХАМТДАА



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН



MMCi
Mongolian Management Consultants Institute



ЭРСЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА



Хөгжлийн Шийдэл ТББ нь энтрепренершип хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд олон улсын байгууллагуудын санхүү болон аргагүйн дэмжлэг, төрийн байгууллагуудын бодлого, шийдвэрүүдийн дэмжлэг, банк, санхүүгийн байгууллагууд, бизнесийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

2024 онд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID), Европын Холбоо (EU), Свич-Эйшиа, Азийн Хөгжлийн банк (ADB), Оюу Толгой ХХК, Пипл ин Нийд ОУТББ, Каритас Чех Репаблик ОУТББ, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо зэрэг байгууллагуудтай нягт хамтран ажилласан.

Мөн 2024 онд бид Эдийн Засаг, Хөгжлийн яам, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яам, Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам зэрэг засгийн газрын гол яамдууд, ЖДҮ-ийн газар, Авлигатай Тэмцэх Газар, Зээлийн Батлан Даалтын Сан, 21 аймгийн Засаг даргын тамгын газар, орон нутгийн захиргааны байгууллагууд, хот хөдөөгийн бизнес хөгжлийн төвүүд, салбар бүрийн бизнесийн холбоод, төрийн бус байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллажээ.

Түүнчлэн ЖДҮ-ийн өсөлтийг дэмждэг томоохон банкууд, банк бус санхүүгийн байгууллагуудын оролцоо, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC), Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO), Залуу Бизнесийн Олон Улсын Сүлжээ (YBI), Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (JICA), АМчам зэрэг байгууллагуудын үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдийн арга зүйн туслалцааг авч, хамтран ажиллаж, үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ.



